



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 284

Улаанбаатар хот

“Дорнод худалдаа” ХК-ийн нэгдмэл сонирхолтой
хувьцаа эзэмшигчдээс Компанийн тухай хуулийн
57.1 дэх заалтыг хэрэгжүүлэх, хувьцааг
худалдан авах саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 57.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Дорнод худалдаа” ХК-ийн нийт гаргасан 73,969 ширхэг хувьцааны 91.38 хувь буюу 67,591 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох иргэн Д.Тунгалагтуул /17,48 хувь буюу 12,927 ширхэг/, Ц.Содбаяр /19,90 хувь буюу 14,720 ширхэг/, Ц.Шинэзориг /23,82 хувь буюу 17,621 ширхэг/, Д.Шинэбаяр /30,18 хувь буюу 22,323 ширхэг/ нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 8.62 хувь буюу 6,378 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 8,020 /найман мянга хорь/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2013 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. “Дорнод худалдаа” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдээс бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах санал гаргаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг төлөөлж буй этгээд /Д.Тунгалагтуул/-д үүрэг болгосугай:

1/ Компанийн тухай хуулийн 57.3-т заасны дагуу хувьцааг худалдан авах саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, хувьцааг худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт багтаан хувьцааг худалдан авах саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

000437

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөж ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН